



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 438

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө ашиглах хугацаа,  
үнийг шинэчлэн тогтоож балансаас  
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Ар талын 115 дугаар ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 6 нэрийн, нийт 229,475,750.00 (хоёр зуун хорин есөн сая дөрвөн зуун далан таван мянга долоон зуун тавь) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 137,685,450.00 (нэг зуун гучин долоон сая зургаан зуун наян таван мянга дөрвөн зуун тавь) төгрөгөөр шинэчлэн тогтоож, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа газарт хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, харьяа газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Тээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т хүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИН ДАРГА

Д.НАРАН ЭРЭЛ



Төрийн өмчийн боллого, зохицуулалтын газрын  
2024 оны 9 дугаар сарын 26. Өдрийн  
43.8 дугаар тогтолцлын хавсралт

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ АР ТАЛЫН 15 ДУГААР АНГИЙН  
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ,  
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/Д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Балансын үнэ, хурийтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил	Шилжүүлэн хүлээн авах байгууллага
1	Киа Серато, улсын дугаар 08-40ҮНҮ	2012	1	14,500,000.00	8,700,000.00	3	Төв аймгийн Онцгой байдлын газар
2	Чирэгч трайлер улсын дугаар 45-28ГЧ	2010	1	36,666,000.00	21,999,600.00	3	Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газар
3	Норд бенз Чирэгч толгой, улсын дугаар 98-35ҮНБ	2010	1	43,333,000.00	25,999,800.00	3	Ховд аймгийн Онцгой байдлын газар
4	Эксекаватор, улсын дугаар 89-65ҮБ	2007	1	58,127,000.00	34,876,200.00	3	Ховд аймгийн Онцгой байдлын газар
5	Зилл-131 улсын дугаар 33-05Я	1990	1	7,236,000.00	4,341,600.00	3	Завхан аймгийн Онцгой байдлын газар
6	ХСМГ Автомокран улсын дугаар 11-47ҮБП	2007	1	69,613,750.00	41,768,250.00	5	ОБЕГ-н дэргэдэх 185-р анги
				229,475,750.00	137,685,450.00		
				(хоёр зуун хорин есөн сая дөрвөн зуун далан таван мянга долоон зуун тавь)	(нэг зуун гучин долоон сая зургаан зуун наян таван мянга дөрвэн зуун тавь)		Нийт дүн